



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.20. № 97  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**ТЭШИГ СУМЫН ЭМТ-ИЙН  
ДАРГА Ц.АЛТАНТУЯА ТАНАА**

**Аудитын тайлан хүргүүлэх тухай**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу танай байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар нийт 2,070.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,070.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөгдсөнийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж ажиллана уу.

Жич: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн "20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн хуулийн зохицуулалттай.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг Тэшиг сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2024/54/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Булган аймаг дахь ТАГ-ын дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч : Ж.Энхцоодол Утас:70342580 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: EnkhtsoodolJ@audit.gov.mn Майкрофт аудит ХХК аудитор: Г.Майцэцэг Утас: 89107138 Цахим хаяг: gombodorjmaitsetseg@gmail.com Ахлах Аудитор: Б.Нарантуяа Утас:99138050 Цахим хаяг: narannarka18@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.19 № 81

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ТЭШИГ СУМЫН ЭМТ-ИЙН  
ДАРГА Ц.АЛТАНТУЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэшиг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэшиг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тэшиг сумын ЭМТ нь гүйцэтгэлийн санхүүжилтээр санхүүжиж, 1 хөтөлбөр 4 зориулалт арга хэмжээний хүрээнд 993,511.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,042,164.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

000502072

Тэшиг сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 21-ний Б/18 тоот захирамжаар 30 хүний бүтэц орон тоотой үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэснийг Сангийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/047 тоот тушаалаар бүтэц орон тоог 27-ээр баталж 2024 онд 27 орон тоотой үйл ажиллагаагаа явуулжээ.

Тайланд онд 48,641.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 911,015.6 мянган төгрөгийн хөрөнгөтэй болсон байна. удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  ЖЭНХЦООДОЛ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	237,761,803.67	248,587,561.81
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	130,004,230.64	3,586,098.86
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	130,004,230.64	3,586,098.86
3121	Төгрөг	130,004,230.64	3,586,098.86
31211	Төрийн сангийн харилцах	130,004,230.64	3,586,098.86
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	<b>АВЛАГА</b>	15,909,977.00	148,801,325.18
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,368,770.50
333	Татаас, санхүүжилтийн авлага	15,909,977.00	147,432,554.68
34	<b>УРЬДЧИЛГАА</b>		
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	91,847,596.03	96,200,137.77
351	Түүхий эд материал	31,089,410.69	41,962,770.43
3511	Тусгай зориулалттай материал	2,114,000.00	18,608,934.50
3513	Эм боох материал	28,975,410.69	23,353,835.93
354	Хангамжийн материал	60,758,185.34	54,237,367.34
3541	Бичиг хэргийн материал	723,160.00	808,160.00
3542	Аж ахуйн материал	41,734,445.34	37,685,810.34
3544	Түлш, шатах тослох материал	1,371,180.00	1,000,000.00
3545	Барилгын засварын материал	8,572,000.00	9,021,000.00
3546	Хүнсний материал	8,207,400.00	5,572,397.00
3547	Бусад хангамжийн материал	150,000.00	150,000.00
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		
II	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	555,109,833.71	504,214,914.55
37	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	555,109,833.71	504,214,914.55
392	Биет хөрөнгө	539,609,033.71	489,164,114.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	262,176,338.76	262,176,338.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-95,624,928.60	-114,651,068.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	258,462,468.00	271,038,005.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-106,960,323.47	-128,235,981.97
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,999,089.52	310,383,881.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-96,070,656.59	-140,158,449.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,836,125.40	50,829,125.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,377,829.31	-22,386,485.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	187,500.00	187,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,750.00	-18,750.00
393	Биет бус хөрөнгө	15,500,800.00	15,050,800.00
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-900,000.00	-1,350,000.00

39303	Бусад биет бус хөрөнгө	15,050,800.00	15,050,800.00
III	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	792,871,637.38	752,802,476.36
IV	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		6,707,056.00
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		6,707,056.00
413	Өглөг		6,707,056.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		6,494,156.00
4136	Бусад өглөг		212,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг		142,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		70,400.00
414	Урьдчилж орсон орлого		
42	<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
422	Урт хугацаат зээл		
V	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	792,871,637.38	746,095,420.36
51	Засгийн газрын хувь оролцоо	792,871,637.38	746,095,420.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	244,527,471.75	244,527,471.75
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	395,266,654.28	348,490,437.26
5121	Өмнөх үеийн үр дүн	395,266,654.28	395,266,654.28
5122	Тайлант үеийн үр дүн		-46,776,217.02
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,077,511.35	153,077,511.35
VI	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	792,871,637.38	752,802,476.36

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,230,564,128.24	1,230,564,128.24
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	57,832,088.68	57,832,088.68
120	Нийтлэг татварын бус орлого	32,627,399.84	32,627,399.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	954,560.00	954,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	954,560.00	954,560.00
120009	Бусад орлого	161,674.00	161,674.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,984,640.00	3,984,640.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	27,526,525.84	27,526,525.84
122	Тусламжийн орлого	25,204,688.84	25,204,688.84
122001	Хандив тусламж /дотоод/	25,204,688.84	25,204,688.84
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,172,732,039.56	1,172,732,039.56
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,065,000.00	31,065,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,065,000.00	1,065,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,698,000.00	57,698,000.00
132001	рсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,698,000.00	57,698,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,083,969,039.56	1,083,969,039.56
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,083,969,039.56	1,083,969,039.56
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	1,277,340,345.26	1,277,340,345.26
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,277,340,345.26	1,277,340,345.26
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,267,391,863.10	1,267,391,863.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	780,125,272.90	780,125,272.90
210101	Үндсэн цалин	410,474,949.79	410,474,949.79
210102	Нэмэгдэл	296,323,544.22	296,323,544.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,609,211.00	20,609,211.00
210104	Урамшуулал	52,717,567.89	52,717,567.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,361,900.76	110,361,900.76
210201	Тэтгэврийн даатгал	83,793,700.76	83,793,700.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,642,400.00	6,642,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,321,000.00	3,321,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,321,000.00	3,321,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,283,800.00	13,283,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,249,517.84	44,249,517.84
210301	Гэрэл, цахилгаан	4,304,103.84	4,304,103.84
210302	Түлш, халаалт	32,018,000.00	32,018,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,927,414.00	7,927,414.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,563,722.00	50,563,722.00
210401	Бичиг хэрэг	6,904,600.00	6,904,600.00
210402	Тээвэр, шатахуун	35,772,922.00	35,772,922.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,520,300.00	1,520,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,365,900.00	6,365,900.00
2105	Нормативт зардал	149,404,324.60	149,404,324.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	126,318,451.60	126,318,451.60
210502	Хоол, хүнс	12,725,473.00	12,725,473.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,360,400.00	10,360,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,047,000.00	4,047,000.00
210604	Урсгал засвар	4,047,000.00	4,047,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,660,000.00	9,660,000.00
210702	Дотоод албан томилолт	9,660,000.00	9,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,553,892.00	3,553,892.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,486,700.00	2,486,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,000.00	86,000.00
210807	Газрын төлбөр	15,192.00	15,192.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	390,000.00	390,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	115,426,233.00	115,426,233.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,889,985.00	15,889,985.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,536,248.00	99,536,248.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,948,482.16	9,948,482.16
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,948,482.16	9,948,482.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,948,482.16	9,948,482.16
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	-46,776,217.02	-46,776,217.02
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>		
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>		
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		
V	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	-46,776,217.02	-46,776,217.02

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	1,042,164,021.88	1,042,164,021.88
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	954,560.00	954,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	954,560.00	954,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	954,560.00	954,560.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	954,560.00	954,560.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,041,209,461.88	1,041,209,461.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,065,000.00	31,065,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,065,000.00	1,065,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,698,000.00	57,698,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,698,000.00	57,698,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	952,446,461.88	952,446,461.88
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	952,446,461.88	952,446,461.88
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	1,149,130,153.66	1,149,130,153.66
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,149,130,153.66	1,149,130,153.66
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,139,181,671.50	1,139,181,671.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,400,299.66	791,400,299.66
210101	Үндсэн цалин	414,135,353.55	414,135,353.55

210102	Нэмэгдэл	305,037,899.10	305,037,899.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,609,211.00	20,609,211.00
210104	Урамшуулал	51,617,836.01	51,617,836.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,925,200.00	98,925,200.00
210201	Тэтгэврийн даатгал	67,269,100.00	67,269,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,914,000.00	7,914,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,957,000.00	3,957,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,957,000.00	3,957,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,828,100.00	15,828,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,749,517.84	45,749,517.84
210301	Гэрэл, цахилгаан	4,304,103.84	4,304,103.84
210302	Түлш, халаалт	33,518,000.00	33,518,000.00
210303	Цэвэр, бохир ус	7,927,414.00	7,927,414.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,132,242.00	50,132,242.00
210401	Бичиг хэрэг	3,038,530.00	3,038,530.00
210402	Тээвэр, шатахуун	37,741,812.00	37,741,812.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,520,300.00	1,520,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,016,100.00	3,016,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,815,500.00	4,815,500.00
2105	Нормативт зардал	106,474,270.00	106,474,270.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	88,605,400.00	88,605,400.00
210502	Хоол, хүнс	11,263,870.00	11,263,870.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,605,000.00	6,605,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,495,000.00	19,495,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,495,000.00	12,495,000.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,660,000.00	9,660,000.00
210702	Дотоод албан томилолт	9,660,000.00	9,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,703,942.00	4,703,942.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,462,650.00	3,462,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	105,100.00	105,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	70,000.00
210807	Газрын төлбөр	15,192.00	15,192.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	475,000.00	475,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,641,200.00	12,641,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,641,200.00	12,641,200.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,948,482.16	9,948,482.16
2132	Бусад урсгал шилжүүлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,948,482.16	9,948,482.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,948,482.16	9,948,482.16

III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	-106,966,131.78	-106,966,131.78
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>		
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	19,452,000.00	19,452,000.00
	Дотоод эх үүсвэрээр	19,452,000.00	19,452,000.00
222001	Тоног төхөөрөмж	19,452,000.00	19,452,000.00
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-19,452,000.00	-19,452,000.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-126,418,131.78	-126,418,131.78
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	130,004,230.64	130,004,230.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,586,098.86	3,586,098.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	3Г-н хувь оролцооны дүн
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	395,266,654.28	792,871,637.38
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			-46,776,217.02	-46,776,217.02
18	.....				
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	244,527,471.75	153,077,511.35	348,490,437.26	746,095,420.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	993,511,746.11	1,168,582,153.66	175,070,407.55	117.62
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	993,511,746.11	1,149,130,153.66	155,618,407.55	115.66
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	993,511,746.11	1,139,181,671.50	145,669,925.39	114.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	820,457,846.11	791,400,299.66	29,057,546.45	96.46
210101	Үндсэн цалин	443,192,900.00	414,135,353.55	29,057,546.45	93.44
210102	Нэмэгдэл	305,037,899.10	305,037,899.10		100
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,609,211.00	20,609,211.00		100
210104	Урамшуулал	51,617,836.01	51,617,836.01		100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,847,800.00	98,925,200.00	24,077,400.00	132.17
210201	Тэтгэврийн даатгал	67,269,100.00	67,269,100.00		100
210202	Тэтгэмжийн даатгал	1,894,500.00	7,914,000.00	-6,019,500.00	417.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	947,400.00	3,957,000.00	-3,009,600.00	417.67
210204	Ажилгүйдлийн даатгал	947,400.00	3,957,000.00	-3,009,600.00	417.67
210205	Эрүүл мэндийн даатгал	3,789,400.00	15,828,100.00	12,038,700.00	417.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,399,600.00	45,749,517.84	28,349,917.84	262.93
210301	Гэрэл, цахилгаан	1,200,000.00	4,304,103.84	-3,104,103.84	358.68
210302	Түлш, халаалт	14,849,600.00	33,518,000.00	18,668,400.00	225.72
210303	Цэвэр, бохир ус	1,350,000.00	7,927,414.00	-6,577,414.00	587.22
2104	Хангамж, бараа материалын зардал	27,125,000.00	50,132,242.00	23,007,242.00	184.82
210401	Бичиг хэрэг	2,624,900.00	3,038,530.00	-413,630.00	115.76

210402	Тээвэр, шатахуун	18,000,100.0 0	37,741,812.00	19,741,712.0 0	- 0	209.68
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,624,900.00	1,520,300.00	104,600.00		93.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	875,100.00	3,016,100.00	-2,141,000.00		344.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,000,000.00	4,815,500.00	-815,500.00		120.39
2105	Нормативт зардал	42,615,100.0 0	106,474,270.00	63,859,170.0 0	- 0	249.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,240,000.0 0	88,605,400.00	58,365,400.0 0	- 0	293.01
210502	Хоол, хүнс	4,625,100.00	11,263,870.00	-6,638,770.00		243.54
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,750,000.00	6,605,000.00	1,145,000.00		85.23
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,416,700.00	19,495,000.00	18,078,300.0 0	- 0	1,376.09
210601	Багаж, техник, хэрэгсэл	666,700.00	12,495,000.00	11,828,300.0 0	- 0	1,874.16
210604	Урсгал засвар	750,000.00	7,000,000.00	-6,250,000.00		933.33
2107	Томилолт, зочны зардал	4,625,100.00	9,660,000.00	-5,034,900.00		208.86
210702	Дотоод албан томилолт	4,625,100.00	9,660,000.00	-5,034,900.00		208.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,025,000.00	4,703,942.00	-3,678,942.00		458.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	375,000.00	3,462,650.00	-3,087,650.00		923.37
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		576,000.00	-576,000.00		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	105,100.00	44,900.00		70.07
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		70,000.00	-70,000.00		
210807	Газрын төлбөр		15,192.00	-15,192.00		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500,000.00	475,000.00	25,000.00		95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,999,600.00	12,641,200.00	-8,641,600.00		316.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,999,600.00	12,641,200.00	-8,641,600.00		316.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		9,948,482.16	-9,948,482.16		

2132	Бусад урсгал шилжүүлэг				
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох		9,948,482.16	-9,948,482.16	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		9,948,482.16	-9,948,482.16	
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		19,452,000.00	19,452,000.00	
	Дотоод эх үүсвэрээр		19,452,000.00	19,452,000.00	
222001	Тоног төхөөрөмж		19,452,000.00	19,452,000.00	
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	312,353,300.00	1,042,164,021.88	729,810,721.88	333.65
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		31,065,000.00	31,065,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		31,065,000.00	31,065,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүн тэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,065,000.00	-1,065,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,000,000.00	30,000,000.00	
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	18,399,600.00	57,698,000.00	39,298,400.00	313.58
132001	Орон нутгийн төсвөөс	18,399,600.00	57,698,000.00	39,298,400.00	313.58
133	<b>ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>				
134	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	293,953,700.00	952,446,461.88	658,492,761.88	324.01
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	293,953,700.00	952,446,461.88	658,492,761.88	324.01

120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		954,560.00	-954,560.00	
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		954,560.00	-954,560.00	
124	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		130,004,230.64	-	130,004,230.64
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,586,098.86	-3,586,098.86	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага нь “Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, “Чанартай үйлчилгээ, хариуцлагатай, ёс зүйтэй тусламж үйлчилгээг хүргэх” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажилласан ба хүний нөөцийн тогтвортой байдал, багаар ажиллах чадвартай, мэргэшсэн байх, ёс зүйтэй байх, цагийн нягтралтай байх гэсэн зарчмуудыг үнэт зүйлсээ болгон ажиллалаа. Тайлант онд тус байгууллага нь 2024 онд 333 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 2240 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.7 байна.

Эрүүл мэндийн төвийн санхүүжилттэй холбоотойгоор 2023 оноос эхлэн өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, сэргээн засах эмчилгээ зэргийг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд энэ онд өдрийн эмчилгээнд 88, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээг 35 хүнийг тус тус хамруулснаар хэвтэн эмчлүүлэгчдийн тоо буурах хандлагатай байна.

Эрүүл мэндийн төвийн 2024 оны батлагдсан төсөв нь 993,511.7 мянган төгрөг, 2024 оны 12-р сарын 31-ний байдлаар төсвийн гүйцэтгэлээр 1,042,164.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 9,7 хувиар нэмэгдүүлсэн байна. Нэг иргэнд ноогдох санхүүжилт буюу улсын төсвөөс 952,446.4 мянган төгрөг, үндсэн тусламж үйлчилгээ буюу гүйцэтгэлээр олсон орлого 109,800.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдэл буюу өмнөх оны үр дүн 168,900.0 мянган төгрөг байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Шилэн дансны хууль, Төрийн болон орон нутгийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хянаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймаг Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны А/229 дугаар журмаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,069.1 мянган төгрөгөөр буюу 5,3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	130,004.20	3,586.00	-126,418.20
Авлага	15909.9	148,801.30	132,891.40
Бараа материал	91,847.50	96,200.10	4,352.60
Үндсэн хөрөнгө	555,109.80	504,214.90	-50,894.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>792,871.40</b>	<b>752,802.30</b>	<b>-40,069.10</b>
Өр төлбөр		6707.1	6,707.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	244,527.40	244,527.40	0.00
Хуримтлагдсан үр дүн	395,266.60	348,490.40	-46,776.20
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	153,077.50	153,077.50	0.00
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>792,871.40</b>	<b>752,802.30</b>	<b>-40,069.10</b>

Дээрх хүснэгтээс харахад, бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 4,352.6 өсөж, үндсэн хөрөнгө 50,894.9 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого 952,446.4 мянган төгрөг, нийт зарлагыг 1,149,130.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалингийн зардлыг 109,100.0 мянган төгрөгөөр өсөж, 1,001,600.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь урьд оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг дараа оны төсөвт нэмж, төсөвлөн нэмэгдүүлсэнээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302 арга хэмжээг санхүүжүүлэхээр 31,065.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 952,446.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 31,065.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 57,698.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,149,130.1 мянган төгрөг буюу 83.8 хувьтай байгаа нь урьд оны үлдэгдэл мөнгөн хөрөнгө нэмж төсөвлөсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80302 нэг иргэнд ноогдох норматив	571,933.1	569,759.9	2,173.4	99.6
2	81603 үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	121,161.0	107,424.5	13,736.5	88.6
3	83601 нэмэлт олон улсын байгууллагаас олгосон	2,429.6	2,429.6	0	100
4	83603 нэмэлт дээд шатны төсвөөс хувиарласан	168,897.1	168,897.1	0	100
5	80111- ОН-ын урсгал үйл ажиллагаа	52,098.0	52,098.0	0.00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зүйл байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Булган аймаг Тэшиг сумын ЭМТ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан төлилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Майкрофт аудит” ХХК-ий аудитор Г.Майцэцэг, ахлах аудитор Б.Нарантуяа нар гүйцэтгэж, хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг тор орлон гүйцэтгэгч Ж.Энхцоодол нар хэрэгжүүлэв.

Булган аймаг Тэшиг сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,277,340.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,160.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,370.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитийн явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2024 онд нийт 159 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 157 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ 2 байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох

заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Засврын аудитаар шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стометрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Зөвлөмж.

Цалингийн шөнийн илүү цагийг бодохдоо Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй. Зөвлөмж.

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 25 нэр төрлийн дутуу нийт 1.724.273 төгрөгний эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Төлбөрийн акт тогтоох.

Бараа материалын тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 3 нэр төрлийн 346400 төгрөгийн бараа материал дутсан байна. Энэ нь УСНББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Төлбөрийн акт тогтоох.

Тайлант хугацаанд орлого, зарлага, шаардах хуудсыг нягтлан бодогч, няравын гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5 "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна" гэж заасантай нийцэхгүй байна. Албан шаардлага.

Анхны өртөгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлэх, ашиглах боломжгүй хөрөнгүүдийг актлах зэрэг бүртгэлийн ажил хийгдээгүй байгаа нь Энэ нь УСНББОУС-17 "Үндсэн хөрөнгө" заалтыг, Засгийн газрын 2014 оны 297 дугаар "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам" -ыг 1 дүгээр хавсралт, "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ" хэрэгжүүлж ажиллаагүй байна. Зөвлөмж.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	280,6	1	280,6	
Албан шаардлага	0	0	0	0	100
Зөвлөмж	3	18000,0	3	18000,0	100

Нийт дүн	4	18280,6	4	18280,6	100
----------	---	---------	---	---------	-----

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭМД-сангаас эрүүл мэндийн байгууллагуудад эм, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөлсийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхдээ эх олонлогийн, сиситемийн, эмч байцаагчийн гэсэн 3 төрлөөр хассан тул дотоод хяналтыг сайжруулах

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын бус зардал гаргахгүй байх, жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг заавал хийж хэрэгжүүлж үлдэгдлийг баталгаажуулж хэвших, бараа материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан байх.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар уг баримт бичиг хүчин төгөлдөр болно", "Анхан шатны бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэж тус тус заасан байдаг. Тиймээс компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг тамга тэмдгээр баталгаажсан анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байх

Санхүүгийн тайлан болон Анхан шатны баримтыг үдэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, НББ тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу архивлан баримтжуулж, дотоод хяналтыг сайжруулахыг санхүүгийн албанд зөвлөж байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,070.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,070.6 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Эмийн тооллогыг түүврийн аргаар тулган баталгаажуулахад 25 нэр төрлийн дутуу нийт 1.724.2 мянган төгрөгний эмийн дутуу тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийт эмийн зардал зөрүүтэйг илтгэж байна. Төлбөрийн акт тогтоох

Бараа материалын тайлангийн дансны үлдэгдлийг агуулахтай тулган баталгаажуулахад 3 нэр төрлийн 346.4 мянган төгрөгийн бараа материал дутсан байна. Энэ нь УСНБББОУС-12, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" эд хөрөнгийн тооллогыг заавал хийнэ, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2 "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа хийнэ" гэж заасантай нийцэхгүй байна. Төлбөрийн акт тогтоох

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй.

#### 5.3 Зөвлөмж

Шатахууны тайлан, жолоочийн замын хуудсыг стандартын дагуу хөтлөх, стометрийн заалтыг дахин нягтлаж шалгаж байх, шатахууны зарцуулалтын тооцоог нягтлаж байх зэрэг нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.8-т заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс /дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж /-ийг нэмж олгох заалтыг баримтлаж ажиллаагүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо		
Тэшиг сумын ЭМТ	4	2,070.6	2	2,070.6			2	0				
Дүн	4	2,070.6	2	2,070.6			2	0				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								